

ДАРХАН-УУЛ АЙМАГ - 2010 ОН

2010 оны аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх “Дархан хотын 50 жилийн ойг угтсан бүтээн байгуулалт”-ын жил болгон зарлаж, “**Өрхийн хөгжлийг дэмжье**”, “**Дархан - Миний хот**” гэсэн 2 зорилтын хүрээнд 18 арга хэмжээ, 71 ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж ажиллалаа.

1. “**ӨРХИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР**”-ИЙГ БОЛОВСРУУЛАН ГАРГАЖ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ.



“Дархан-Уул аймгийн өрхийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”/2010-2012он/-ийг боловсруулан 136 ажлыг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан.

2. “**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН 40-ӨӨС ДЭЭШ НАСНЫ АЖИЛГҮЙ БОЛОН ТЭТГЭВРИЙН НАСНЫ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ**” ХӨТӨЛБӨР БАТЛАГДЛАА.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 71 дүгээр тогтоолоор “Дархан-Уул аймгийн 40-өөс дээш насны ажилгүй болон тэтгэврийн насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг батлуулж, 40-өөс дээш насны ажилгүй болон тэтгэвэрт гарсан иргэдийн хөдөлмөрийг нь дэмжих, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сургалтад хамруулах, өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар өрх, гэр бүл таатай орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, ажилгүйдлийг бууруулах арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүллээ.



3. “ИРГЭННИЙ ТАНХИМ” АШИГЛАЛТАД ОРЛОО.



Орон нутгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж зэрэг шийдвэрт иргэдийн байр суурь, санал санаачлагыг тусгах, орон нутгийн тулмагдсан асуудлыг иргэдийн оролцоотой нээлттэй хэлэлцүүлэх, иргэдийн санал бодлыг шийдвэрт тусгуулах зорилгоор “Иргэний танхим”-ыг нээн ажиллуулж, 2 сар тутам нэг удаа хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөж, төлөвлөгөөний дагуу 4 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж, нийт 300 гаруй иргэд, иргэний нийгэмийн төлөөлөл оролцсоноос 68 иргэн санал гаргасан байна.


4. “ИРГЭДИЙГ ХҮЛЭЭН АВАХ ӨРӨӨ”-Г АШИГЛАЛТАД ОРУУЛЛАА.



“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хууль”-д заасны дагуу иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, зөвлөгөө, мэдээлэл өгөх, харилцан ярилцах, санал сэтгэгдлээ чөлөөтэй илэрхийлэх боломж бүхий үйлчлүүлэгч, иргэдийн ая тухтай байдлыг хангасан “Иргэдийг хүлээн авах өрөө”-г аймгийн

ЗДТГ болон бүх сумдын ЗДТГ-т нээн ажиллууллаа. “Иргэдийг хүлээн авах өрөө”-ний үйл ажиллагааг өргөтгөх, бизнес эрхлэгчдийг нэг цэгээс мэдээллээр хангах зорилгоор төрийн 17 байгууллага, бизнес хөгжлийн үйлчилгээ үзүүлэгч 1 төрийн бус байгууллагын нийт 97 үйлчилгээний мэдээллийг нэг цэгээс өгөх “Бизнес ширээ-Мэдээлэл зөвлөмжийн үйлчилгээ”-г нэвтрүүлж, нийт давхардсан тоогоор 1380 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч үйлчиллээ.

5. “ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ – 50 БҮТЭЭЛЧ АЖИЛ”-ИЙГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭЛЭЭ.



Дархан хот байгуулагдсаны 50 жилийн ой угтан 50 бүтээлч ажлыг төлөвлөн хэрэгжүүллээ. Дээрх ажлын хүрээнд аймгийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн

салбарт нийт 15,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдлээ.

6. “ДАРХАН -50” ЦОГЦОЛБОРЫГ БҮТЭЭЖ БАЙНА.



Дархан хот байгуулагдсаны 50 жилийн ой угтан иргэд, аж ахуйн нэгж байгууллагын идэвхи санаачлагыг идэвхитэй өрнүүлж, 4.2 га газарт ногоон байгууламж, усан оргилуур бүхий “Дархан-50” цогцолборын бүтээн байгуулалтын ажлын 70 хувийг хийж гүйцэтгэлээ.

Энэ ажилд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 68.5 сая төгрөгийн материалын, 76,0 сая төгрөгийн мөнгөн хандив, 8.6 сая төгрөгийн машин, механизмийн дэмжлэг туслалцаа үзүүлээ.

7. ХЯНАЛТЫН НЭГДСЭН СИСТЕМ” АШИГЛАЛТАД ОРУУЛЛАА.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийнхээ амгалан тайван ажиллаж



амьдрах нөхцлийг хангах зорилгоор улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Төрийн байгууллагуудын нэгдсэн сүлжээ, “Хяналтын нэгдсэн систем”-ийг нэвтрүүлж, орон нутагт уг системийг нэвтрүүлсэн анхны аймаг боллоо.

“Е-Дархан” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллагуудын нэгдсэн сүлжээ, мэдээллийн тогтолцоог бий болгох,

иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ, мэдээ, мэдээллийг ил тод, түргэн шуурхай болгох зорилгоор Мэдээлэл, технологийн албыг шинээр байгуулж, хэвлэл, мэдээлэл, төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн үйл ажиллагааг хариуцан, төрийн 88 байгууллагын 62 объектыг шилэн кабелийн сүлжээнд холбож мэдээллийн нэгдсэн тогтолцоо бий болголоо.



8. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ОРОН СУУЦНЫ ДЭЭВРИЙН ЗАСВАР



Нийтийн эзэмшлийн орон сууцны 57,7 мянган м² талбай бүхий дээврийн засвар, цахилгааны шатны засварын ажлыг төвлөрсөн болон орон нутгийн төсвийн нийт 970,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж гүйцэтгэлээ. Энэ нь нийт орон сууцны 30%-ийг эзэлж байгаа бөгөөд ирэх 2011 онд 1,3 тэрбум төгрөгөөр үргэлжлүүлэн хийх болно.

9. УСАН ХАНГАМЖИЙН ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛТ



Япон улсын Жайка ОУБ-ын “УСАН ХАНГАМЖИЙН ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛТ” / 2009-2011 / төслөөр “Дархан-Ус суваг” ОНӨХК-д 9.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, Дархан сумын 5, 6 дугаар багийн цэвэр усны шугамыг солих, 1, 2 дугаар өргөгч станцын тоног төхөөрөмжийн засвар шинэчлэлтийн ажлууд хийгдлээ.

10. “НЭГ БАЙГУУЛЛАГА - НЭГ ТӨГӨЛ” ХӨДӨЛГӨӨН ӨРНҮҮЛЛЭЭ.

“Нэг байгууллага-Нэг төгөл” болон “Монголоо ногооруулья” аяны хүрээнд аймгийн хэмжээнд 123 аж ахуйн нэгж, байгууллага, 8763 иргэн өөрийн хөрөнгөөр 34499 ш мод бутыг тарьж, 68,0 сая төгрөг зарцууллаа.



Дархан-Уул аймгийн 2010 оны ажлын амжилтуудаас дурьдвал:

- Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжил, бүтээн байгуулалтад үнэтэй хувь нэмэр оруулсан ажил амжилтаараа ЗТБХБЯам, Монголын Барилгачдын Үндэсний Ассоциацаас “Барилга хот байгуулалтын чиглэлээр орон нутагтаа хамгийн их бүтээн байгуулалт өрнүүлсэн хот” өргөмжлөл,
- Төрийн архивын улсын үзлэгт “Маш сайн” үнэлгээ авч, аймгуудаас 1 дүгээр байр

- Улсын хэмжээний гамшигаас хамгаалах иж бүрэн сургуулийг зохион байгуулж , “Дүүрэн хангалттай” үнэлгээ авсан
- Үндэсний спортын 4 дүгээр их наадамд манай аймгийн баг, тамирчид улсад 3 дугаар байр
- 2010 оны элсэлтийн Ерөнхий шалгалтын дүнгээр улсын хэмжээнд 518.3 оноогоор 1 дүгээр байр,
- Агентлагууд 2010 оны үйл ажиллагааныхаа үр дүнгээр:
- **Улсад 1 дүгээр байр:**
 - Боловсрол соёлын газар
 - Цагдаагийн газар
 - ХХААЖДҮГ-ын Мал үйлчилгээний алба
 - Нийгмийн даатгалын хэлтэс
- **Улсад 2 дугаар байр**
 - Биеийн тамир спортын газар
 - Гааль
- **Улсад 3 дугаар байр**
 - Онцгой байдлын газар
- **Улсад 4 дүгээр байр**
 - Мэргэжлийн хяналтын газар
 - Стандартчлал хэмжил зүйн хэлтэс
- **Улсад 5 дугаар байр**
 - Эрүүл мэндийн газар

ТАНИЛЦСАН:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА

/ Т. ГАНБОЛД /